



ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2025 оны 08 сарын 05 өдөр

Дугаар А1447

Хэрлэн сум

Яаралтай дархлаажуулалтын ажлыг зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалт, Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 5 дугаар зүйл, 6 дугаар зүйлийн 6.1, 6.4, 6.5, 6.6 дахь хэсэг, 9 дүгээр зүйлийн 9.1, 9.4, 9.5, 9.6, 9.7 дахь хэсэг, 9.8.1, 9.8.2 дахь заалт, 28 дугаар зүйлийн 28.4 дэх хэсэг, Мал эмнэлгийн ерөнхий газрын даргын А/207 дугаар тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Дорнод аймгийн Хэрлэн суманд малын гоц халдварт Үхрийн арьс товруутах өвчин эмнэл зүйн шинж тэмдэг илэрсэн тул эрсдэл бүхий Баян-овоо, Баянхутаг, Хэрлэн, Мөрөн сумдад үхрийн арьс товруутах өвчнөөс урьдчилан сэргийлэх яаралтай дархлаажуулалтын ажлыг 2025 оны 08 дугаар сарын 04-ний өдрөөс эхлэн 2025 оны 08 дугаар сарын 18-ны өдрийг хүртэл 14 хоногийн хугацаанд шуурхай зохион байгуулсугай.

2.Малчдад урьдчилан мэдэгдэж тарилгын хашаа, хоолойг бэлтгүүлэх, дархлаажуулалтад ажиллах хүн хүч, машин техник, шатах тослох материалын бэлэн байдлыг хангуулж ажиллахыг сумын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

3.Яаралтай дархлаажуулалтад шаардагдах вакцин, мэргэжил арга зүй, заавар зөвлөмжөөр хангаж ажиллахыг Мал эмнэлгийн газрын дарга (Н.Анхбаяр)-д, захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (Б.Өнөрцолмон)-д тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Д.АЮУРБУНЬ



2000

۵. متن

۳۵ ۲۰ ۴۵

مصر و مصر، اندر مصر

كُنْتُمْ مِثْلَهُنَّ سَوَاسِثًا مِمَّنْ بَيْنَ يَدَيْكُمْ
يَوْمَ لَمْ يَكُنْ لَكُمْ كِتَابٌ هَدًى إِلَّا رَجَدَكُمْ
فِي ضَلَالٍ كَثِيرٍ وَبُعِذْتُكُمْ فَمِنْكُمْ

[illegible]

حسن محمد حسن